

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Иргэний бүртгэлийн тухай хуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.1.4 дэх заалт нэмсүгэй:

“6.1.4.Хэрэв нөхөн үржихүйн туслах технологийг ашиглаж хүүхэдтэй болсон бол Гэр бүлийн тухай хуулийн 27.1-д заасан гэрээ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“32.4.Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 129.1.7-д заасан хугацаанд шүүхийн эвлэрүүлэн зуучлагч гэрлэгчдийг эвлэрүүлэхэд дэмжлэг үзүүлж дараах арга хэмжээг авна:

32.4.1.гэрлэгчидтэй хамтарсан болон ганцаарчилсан уулзалт хийж, гэрлэлт цуцлуулах болсон шалтгаан үндэслэлтэй эсэхийг тогтоох, гэрлэлт цуцлуулахын үр дагаврыг тайлбарлах;

32.4.2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32.4-т зааснаас гадна өмгөөлөгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулж, гэрлэгчдэд зөвлөгөө өгөх;

32.4.3.гэрлэгчдийг шаардлагатай сургалт, мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулах;

32.4.4.хуульд заасан бусад арга хэмжээ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дараах агуулга бүхий 144<sup>1</sup> дүгээр зүйлийг нэмсүгэй:

#### **“144<sup>1</sup> дүгээр зүйл. Хүүхэд үрчлэх хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх**

144<sup>1</sup>.1. Хүүхэд үрчлэх хүсэлтийг хүүхдийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

144<sup>1</sup>.2. Хүүхэд үрчлэх тухай хүсэлтэд хүүхэд үрчлэх болсон шалтгааныг тодорхой дурдаж, холбогдох нотлох баримт, эрх бүхий байгууллагын үнэлгээ, дүгнэлтийг хавсаргана.

144<sup>1</sup>.3. Зохигчийн төлөөлөгч, өмгөөлөгч болон хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллагын төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

144<sup>1</sup>.4. Шүүх хүүхдийг үрчлүүлэх шийдвэр гаргахдаа эрх бүхий байгууллагын үнэлгээ, дүгнэлтийг харгалзаж шийдвэр гаргана.”

**2 дугаар зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.4 дэх заалтын “хүүхэд” гэсний дараа “үрчлүүлэх,” гэж нэмсүгэй.

**3 дүгээр зүйл.** Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“132.4. Харин гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон, эсхүл эхнэр, нөхөр хоёрын хэн нэг нь сураггүй алга болсон, эсхүл эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан, эсхүл гурваас доошгүй жилээр хорих ялаар шийтгүүлсэн, эсхүл хүйсээ өөрчилсөн бол шүүгч энэ зүйлийн 132.1-д заасан арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## **ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.2, 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн тогтоолын “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2 дугаар хавсралтын зорилтын 2.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

“2.3.13. Гэр бүлийн тогтвортой хамтын амьдралыг дэмжих, тогтвортой хамтран амьдарч байгаа гэр бүлд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.”

2. Энэ тогтоолыг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг